

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2014 он)

Зөвлөмж 201401/01. МИ-8 нисдэг тэрэгний Нислэгийн ашиглалтын зааврын 4.14.8-д заасан салхи 5 м/сек-ээс их үед агаараас талбай сонгохгүй байх, мөн зааврын 4.8.1.6-д уулархаг бүсэд буултанд хөндлөнгийн салхи 3 м/сек-ээс ихгүй байх заалтыг тус тус мөрдөж ажиллах.

Зөвлөмж 201401/02. МИ-8 нисдэг тэрэгний Нислэгийн ашиглалтын зааврын 2.6.7-д заасан буух талбайн налуу 0,05, гадаргууны тэгш бус нь 0,1 метрээс ихгүй байх заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмж 201401/03. Олон удаагийн давтамжтай нислэг үйлдэх МИ-8 нисдэг тэрэгний хээрийн буух талбайг Нислэг ашиглалтын заавар /РЛЭ.2.6 ба 4.14.19/-ын дагуу урьдчилан бэлтгэж нислэг үйлдэж байх.

Зөвлөмж 201401/04. Монгол улсын хилийн бүс болон тусгай хамгаалалтын газарт нисдэг тэргээр нислэг үйлдэх үед Монгол Улсын холбогдох хуулийн заалтуудыг мөрдөж, зөвшөөрөл авч нислэг үйлдэж байх.

Зөвлөмж 201401/05. Нисдэг тэргээр талбай сонгон буух үед агаарын хөлөг газардсаны дараа буултын мэдээллийг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад мэдэгдэж байх.

Зөвлөмж 201401/06. Нислэгийн төлөвлөгөөнд тусгах нисдэг тэрэгний буух талбайн байршлыг тодорхойлсон координатыг нарийвчлалтай тогтоож, тоон утгийг олон улсын стандартын дагуу бичиж байх.

Зөвлөмж 201401/07. Тээврийн ангилалын нислэг үйлдэж байгаа нисдэг тэрэгний нислэгийн үйл ажиллагаанд хөдөлгөөний хяналтын тогтолцоог бүрдүүлж ажиллах.

Зөвлөмж 201401/08. МИ-8 нисдэг тэрэгний нисгэх багийн хэлний түвшингийн шаардлагыг тухайн агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын заавар, битүү бүхээгийн дадлагыг бүрэн авч чадах хэмжээнд ба Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын Хавсралт 1 стандартын мэргэжлийн хэлний түвшингийн шаардлагад хүргэх.

Зөвлөмж 201401/09. Тээврийн ангилалын нисдэг тэрэгний нисгэх багийн бүрэлдэхүүнийг бэлтгэх битүү кабины дадлагыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын шаардлага Full Flight Simulator-ын 4 өөс доошгүй түвшингийн байгууламжид дадлага өгч байх.

Зөвлөмж 201401/10. Тээврийн ангилалд хамаарагдах хөөрөлтийн жин нь 9 тонн, 10-аас илүү зорчигч тээвэрлэдэг МИ-8 нисдэг тэргээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа тээвэрлэгчийг зохицуулах дүрмийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201401/11. МИ-8 нисдэг тэрэгний Үйлдвэрлэгч улсаас гаргасан нисгэх бүрэлдэхүүнийг бэлтгэх хөтөлбөр /ППЛС-программы подготовки лётного состава на вертолёте МИ-8/-ийг Иргэний нисэхийн дүрэмд тусгаж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201401/12. МИ-8 нисдэг тэрэгний Үйлдвэрлэгч улсаас гаргасан нисдэг тэрэгний нислэгт тэнцэх чадварын шаардлага /НЛГВ норма летной годности вертолёт/- ыг Иргэний нисэхийн дүрэмд тусгаж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201405/13. Тухайн нисэгч зөөлтийн нислэгийн хөтөлбөрөө хэрхэн хангасан талаар зөөсөн багш нисгэгчийн саналыг албан ёсоор гаргуулж, нислэгийн дэвтэрт бичүүлж хөөрөлт, буултын дадлага хийлгэсний дараа уг агаарын хөлгөөр нисэх эрх бүхий нисгэгчээр шалгуулсны үндсэн дээр тухайн агаарын хөлөгт нисэх эрх олгох асуудлыг шийдвэрлэж байх

Зөвлөмж 201405/14. НЦУТ-ын болон АW03-ын алсын барааны харагдацын зөрүүтэй байгааг арилгах

Зөвлөмж 201405/15. НМЭ байгаа орон нутгийн аэродромын оролт үйлдэх схем дэх мэдээллүүдийг хянан нэг стандартад оруулах

Зөвлөмж 201405/16. Гадаад нисгэгч нарт тавих хяналтыг өндөржүүлэх, ИНД- ээр шалгалт авах болон мөрдүүлэх

Зөвлөмж 201406/17. ИНЕГ-ын Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын газар нь үндэсний нисэх бүрэлдэхүүн болон агаарын хөлгийн техник үйлчилгээний боловсон

хүчин бэлтгэх чанаржуулах, төрөөс баримтлах бодлогын хүрээнд богино болон дунд хугацааны бодлого төлөвлөлтийг боловсрууж батлуулах, хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201406/18. ИНЕГ үндэсний боловсон хүчний нөөц бололцоонд тулгуурлан Монгол улсын цаг агаарын эрс тэс уур амьсгал, физик газар зүйн онцлог, хүн амын суурьшилтын бүтцэд тохирсон иргэний агаарын тээврийн улсын болон хувийн хэвшлийн нисэх компаниудад орон нутгийн болон олон улсын нислэгт ашиглах агаарын хөлгийн маягийг тогтоох түүнд төрөөс хяналт тавих, зохицуулах, хязгаарлалт хийх эрх зүйн актыг боловсруулж, мөрдөх.

Зөвлөмж 201408/19. Шинэ Зеландын ИНД101-д “gyrogliders and parasails” өөр төрлийн нисэх хэрэгсэл заасныг манай ИНД-101.1.4-д “Автожир”, ИНД-101.3-д “Автожир” гэж буруу орчуулсаныг дүрмэнд өөрчлөлт оруулан залруулах

Зөвлөмж 201408/20. “Топ Экстрим Экшин Монголиа” ХХК-ний үйл ажиллагааны заавар, журмыг ИНД-149, ИНД-103, ИНД-91,ИНД-61,ИНД-11 дагуу дахин хянаж баталгаажуулж, хяналт тавих

Зөвлөмж 201408/21. Аадар борооны үүл, аянга цахилгаан нислэгийн замд тааралдсан тохиолдолд ямар зайд тойрох, аэродромын бүсэд ажиглагдвал хөөрөлт, буулт үйлдэх эсэх асуудлаар Иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт оруулах

Зөвлөмж 201408/22. НЦУТ цаг уурын үзэгдлийн түр зуурын хэлбэлзлийг урьдчилан мэдээлэхдээTAF мэдээний өөрчлөлтийг илэрхийлдэг “TEMPO” хэсэгт Annex 3-ийн нэмэлт 5-ын хүснэгт A5-2 –т заасны дагуу 1 цагаас ихгүйгүйгээр тухай бүр тусгаж байх

Зөвлөмж 201408/23. Хөдөлгүүрийн ашиглалтын тогтоогдсон хязгаарыг давсан асуудлаар тус албанаас FDR-ийн бичлэгт үндэслэн хийсэн дүгнэлт, үйлдвэрлэгчийн 2014 оны 7-р сарын 23-нд ирүүлсэн майл-ийн дагуу уг агаарын хөлгийн хоёр хөдөлгүүрийн ашиглалтыг түр зогсоох

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА